

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 4 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**
(Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам)

/2017 оны жилийн эцэс/

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин, үр дүн %-иар	Зарцуулсан хөрөнгө эх үүсвэр /сая.төг/	Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хэрэгжилт хувиар	
1	2	3	4	5	6	7	8	9	
НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО									
Зорилт 5. Геологи, уул уурхайн салбарын хөгжлийг дэмжиж, хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.									
5.1	МУТХҮБ-ын 2.1.4, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.59 дэх заалт	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлвийг судлах зорилгоор геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх	1. Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн 22 төслийн үр дүнг хүлээн авах	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар /1:50000 масштаб/	37.0	Улсын төсөв 454,1	1. Үр дүнгийн тайлантай 22 төслөөс 14 төслийн үр дүнг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, сайдын А/171, А/170, А/135, А/134, А/107, А/106, А/61, А/60, А/59, А/57, А/56, А/02 дугаар тушаалуудаар хүлээн авсан. Ингэснээр нийт нутаг дэвсгэрийн 37.4% бүрэн хамрагдсан. ЭБМЗ-өөр Цогт-50, Бурхант толгой-50, Дэвсгийн нуруу-50, Хөхөлзөгийн нуруу-50, Хулгарын элс-50, Улаантолгой-50, Өлийн овоот-50, Шивээт-50 төслүүдийн үр дүнг хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.	100%	
			2. Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн 14 төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх				3831,1	2. Үргэлжлэн хэрэгжих 12 төслийн төсөв, төлөвлөгөөг сайдын А/96 дугаар тушаалаар, тодотголыг сайдын А/214 дүгээр тушаалаар батлан үргэлжлүүлэн хэрэгжүүлэв. Төслүүдийн хээрийн судалгааны ажилд шуурхай хяналтыг хийж хээрийн анхдагч баримт материалыг хүлээн авсан.	100%
			3. Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн 4 төслийг				966,1	3. Төсвийн хөрөнгөөр 2016 онд шинээр эхлэх 2 төслийг Сангийн яамны шийдвэрээр 2017 онд хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан 2017 онд нийтдээ 6 төслийг шинээр хэрэгжүүлж эхэлсэн. Шинээр хэрэгжүүлэх төслүүдийг	100%

			шинээр хэрэгжүүлэх			төсөв, төлөвлөгөөг сайдын А/96, тодотголыг А/214 дүгээр тушаалаар батлуулсан. Төслүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Төслүүдийн 2017 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авсан.	
			4. Сэдэвчилсэн судалгааны Баруун Монголын цул сульфид-2014, Металлогени-2014, Геомэдээллийн сан-2013, Сансрын зургийн тайлалт-2013 төслүүдийг хэрэгжүүлж дуусган үр дүнг хүлээн авах		742,1	4. Төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлж дуусах Баруун Монголын цул сульфид-2014, Металлогени-2014, Геомэдээллийн сан-2013, Сансрын зургийн тайлалт-2013 төслүүдийн төсөв, төлөвлөгөөг сайдын А/96, төслүүдийн ажлын аргачлал, хэмжээ, төсөвт тодотгол хийж сайдын А/241 дүгээр тушаалаар батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан. Үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.	70%
			5. Төв, зүүн бүсийн алтны нөөцийн хэтийн төлөвийн үнэлгээ-2017 төслийг шинээр эхлүүлэх		1528,0	5. Монгол орны төв, зүүн бүсийн алтны нөөцийн хэтийн төлөвийн үнэлгээ хийх геологийн судалгааны ажлын ТЗМ-Алт-2017 төслийн геологийн даалгавар болон ажлын төлөвлөгөө, төсвийг сайдын А/96 дугаар тушаалаар баталсан. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн. Төслийн төсөв, төлөвлөгөөнд тодотгол хийж сайдын А/241 дүгээр тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Төслийн хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авсан.	100%
			6. “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн		142,4	6. МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени”	100%

			процесс ба металлогени” олон улсын төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх				төслийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хүлээн авсан. Төслийн 4-р үе шатны ажлыг 2018 оноос хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
			7. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох 4 төслийн үр дүнг хүлээн авах	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар /1:200000 масштаб/	100.0	40,4	7. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох 4 төслийн үр дүнгийн 4 тайланг хүлээн авахаас УГЗ-200-ТМ-VI төслийн үр дүнгийн тайланг сайдын А/108 дугаар тушаалаар хүлээн авсан. УГЗ-200-ТМ-V, УГЗ-200-ДМ-VI, VII төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.	100%
			8. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх төслийг L хавтгайн хэмжээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх			462,0	8. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх төсөл K хавтгайн хэмжээнд үргэлжлэн хэрэгжиж байна. Төслийн 2017 оны төсөв, төлөвлөгөөг сайдын А/96 дугаар тушаалаар баталсан. Төслийн ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн тодотгож сайдын А/184 дүгээр тушаалаар батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан. 2017 хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авсан.	100%
			9. Агаарын геофизикийн Алтай-I, II, Ховд-I төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх			1303,0	9. Агаарын геофизикийн Алтай-1, Алтай-2, Ховд-1 төслүүдийн 2017 оны ажлын төлөвлөгөө, төсвийг сайдын А/96 дугаар тушаалаар батласан. Төслүүдийн хээрийн судалгааны ажлын хэмжээ, арга аргачлалд тодотгол хийж сайдын А/184 дүгээр тушаалаар батлуулан ажлыг эхлүүлсэн. Төслүүдийн 2017 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авсан.	70%
5.2	МУТХҮБ-ын 2.1.4, Зорилт 2,	Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулал	1. Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд	Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын	20.0		1. Оюу толгойн ордыг ашиглах талаар холбогдох хууль (Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай, Компанийн тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль	100%

ЗГҮАХ-ийн 1.24 дэх заалт	тын ажлыг эрчимжүү лэх, Тавантол гойн орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцлийг байгуулж, төслийн үйл ажиллагааг эхлүүлэх	дэмжлэг үзүүлж, төслийн хэрэгжилтэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах	ажлын явц, хувиар			орчны багц хууль гэх мэт) , тогтоомж ("Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай" УИХ-ын 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоол), дүрэм (Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм), журмыг (Төрийн болон орон нутгын өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай) мөрдүүлэн, санал, зөвлөмж өгч бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд далд уурхайн босоо амны малталтууд, хөндлөн нэвтрэлтүүд, туслах дэд бүтцийн ажлууд ахицтай үргэлжилж байна. 2017 оны 3 дугаар улирлын байдлаар хос налуу амын нийт нэвтрэлт (конвейерийн налуу ам, үйлчилгээний налуу ам) 1600 метр болоод байна. Далд уурхайн 2 дугаар босоо аманд 1284 метр нэвтрэлт хийхээс 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 1268 метрт хүрээд байгаа бөгөөд 2018 оны нэгдүгээр сард 1284 метрт хүрэхээр тооцоолж байна. 5 дугаар босоо аманд 1178 метр нэвтрэлт хийхээс 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 1007 метрт хүрээд байна. Хөндлөн/хэвтээ нэвтрэлийн ажлууд 6101 метрт хүрсэн бөгөөд гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу явагдаж байна. Төслийн нийт капитал хөрөнгө оруулалтын төсөв 5.34 тэрбум ам доллар бөгөөд нийт 1.4 тэрбум ам.долларыг Монгол компаниудтай гэрээлээд байна. Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 155 дугаар Захирамжаар "Уул уурхайн Бодлогын зөвлөл"-ийг байгуулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 256 дугаар тушаалаар Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн төлөвлөгөөнд санал	
--------------------------------	--	--	----------------------	--	--	---	--

						дүгнэлт өгөх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд санал, дүгнэлтээ танилцуулсан.	
		2. Тавантолгойн ордыг иж бүрэн, оновчтой ашиглах төсөл боловсруулах	Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээ хэлцлийг байгуулах ажлын явц, хувиар	100.0		Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 104 тоот захирамжаар Тавантолгойн ордод хөрөнгө оруулж, хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцөлийг сайжруулж, хэлэлцээр хийх ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн удирдамжийг баталсан. Ажлын хэсэг дараах үндсэн чиглэлээр хөрөнгө оруулагчтай хэлэлцээг хийж байгаа болно. Үүнд: (i) Төсөл хэрэгжүүлэгч компанийн 51-ээс доошгүй хувийг Монголын тал, 49-өөс дээшгүй хувийг Шэнхуа групп тус тус эзэмших бөгөөд Тавантогойн ордоос олборлосон нүүрсийг БНХАУ-ын болон гуравдагч зах зээлд борлуулах бүтцийг тодорхойлж, тохиролцох, (ii) Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж, ашиглах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх компанийн 51 хувийг төрийн өмчит компани эзэмших, (iii) Төмөр замын суурь бүтцийг 2.5 жилийн хугацааны дотор барьж, ашиглалтад оруулах, төсөл хэрэгжиж дууссаны дараа төмөр замын суурь бүтцийг барьж, ашиглах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх компанийн 49 хувийг төрийн өмчит компанид үнэ төлбөргүй эзэмших нөхцөлөөр гэрээ байгуулах; (iv) Ашигт малтмалын тухай хуулийн 35.11-д олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт нэн тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр	70%

						нийлүүлнэ гэж заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч компани нь одоо байгаа угаах үйлдвэрийг ашиглах, хүчин чадлыг нэмэгдүүлж, шинээр үйлдвэр барих замаар нүүрсээ экспортлох, (v) Тавантолгойн ордыг ашиглах ТЭЗҮ-ийг гэрээ байгуулснаас хойш 9 сарын дотор боловсруулах; (vi) Төсөл хэрэгжүүлэгч компанийн Монголын талын хөрөнгө оруулагч компанийн хувьцаа эзэмшигчдийн гэрээний талаар Монголын талаас оролцогч компанитай тохиролцох гэж тус тус заасан. Хөрөнгө оруулагчид болох БНХАУ-ын Чайна Шэнхуа Энержи Компани Лимитед, Энержи Ресурс ХХК болон Сумитомо Корпорацийн төлөөлөлтэй уулзалт хийж ажлын хэсгийн удирдамжид заасан асуудлаар Монголын талын саналыг хүргүүлээд байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдын зүгээс ямар нэг хариу ирүүлээгүй байна.	
			3. Тавантолгойн ордыг иж бүрэн, оновчтой ашиглах төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх			3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар 2017 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд Стратегийн ач холбогдол бүхий Таван толгойн бүлэг ордод олборлолт, баяжуулалт хийж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцсан. Түүнчлэн Таван толгойн ордыг иж бүрнээр ашиглах тухай (төмөр зам, авто зам, баяжуулах үйлдвэр, усан хангамж, ордыг түшиглэсэн аж үйлдвэрийн цогцолбор) төлөвлөгөө боловсруулан Монгол Улсын Ерөнхий сайдад 2018 оны 1 дүгээр сарын 8-ний өдөр, Засгийн газрын хуралдаанд 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр тус тус танилцуулсан.	100
			4. Тавантолгойн ордын төслийг Улсын Их			4. Тавантолгойн ордын төслийг Улсын Их Хуралд танилцуулах ажлын хүрээнд Таван толгойн ордыг иж бүрнээр ашиглах тухай төлөвлөгөөг боловсруулан Засгийн	70%

			Хуралд танилцуулах				газрын хуралдаанд 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр танилцуулаад байна.	
5.3	МУТХҮБ-ын 2.1.4, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.68 дахь заалт	“Алт-2” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг эхлүүлэх	1. “Алт-2” хөтөлбөрийг боловсруулж батлуулах	Хөтөлбөр боловсруулах ажлын явц, хувиар	100.0		1. “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх зүйл, 2 дугаар зүйлийн 2.68 дахь заалт, “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн хүрээнд “Алт-2” хөтөлбөрийг шинэчлэн үргэлжлүүлэх үүргийг Сангийн яам, Монголбанк, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд өгөгдсөний дагуу “Алт-2” хөтөлбөрийн төслийг Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2016 оны 403, А/68, А/136, А-339 тоот хамтарсан тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг эцэслэн боловсруулж 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 20 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ерөнхий сайдын 2017 оны 17 дугаар захирамжаар “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, уялдуулан зохицуулах, тайлагнах чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай орон тооны бус Зөвлөлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар ахлуулан байгуулсан.	100%
			2. “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж батлуулах				2. Зөвлөлийн дарга буюу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/42 дугаар тушаалаар Хууль эрх зүй, орон нутаг, Санхүүжилт, Геологи уул уурхай, Байгаль орчин нөхөн сэргээлтийн асуудал хариуцсан салбар зөвлөлийг байгуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2017 оны А/66, Сангийн сайдын 202, Байгаль орчин,	100%

						<p>аялал жуулчлалын сайдын А/174, Монгол банкны ерөнхийлөгчийн А-166 дугаар хамтарсан тушаалаар баталсан.</p>	
			<p>3. “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p>			<p>3. “Алт-2” үндэсний хөтөлбөрт тусгагдсан үндсэн 5 зорилтын хүрээнд нийт 43 зорилтод арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2017-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2017 оны 3-р сарын 17-нд “Монгол алт 2017”, 3-р сарын 23-24-нд “Монголын геологи хайгуул 2017” чуулганд хөтөлбөрийн талаар танилцуулга илтгэл хийгдэж, төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоод зөвлөлдөж, хамтын ажиллагааг эхлүүлсэн. “Монгол алт 2017” чуулганд алт үйлдвэрлэлийн төрийн болон бизнесийн 20 гаруй илтгэл тавигдаж, 450 гаруй гадаад, дотоодын төлөөлөгч оролцов. Чуулганы хурлаас алт үйлдвэрлэлтэй холбоотой Зөвлөмж гарч холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. 2017 оны 3-р сарын 24 нд “Алт-2” үндэсний хөтөлбөрийн Геологи уул уурхайн асуудал хариуцсан, Байгаль орчин нөхөн сэргээлтийн асуудал хариуцсан салбар зөвлөл, хяналт үнэлгээний нэгжийн бүрэлдэхүүн Сэлэнгэ аймагт ажиллан, аймгийн Засаг даргын тамгын газрын удирдлага, зарим сумдын Засаг дарга нартай уулзалт зохион байгуулсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн уулын ажлын болон хайгуулын ажлын тайлан, төлөвлөгөө хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулж дуусгах, мөн нөөц нь тогтоогдсон боловч эдийн засгийн эргэлтэд орохгүй байгаа төслүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх үүрэг даалгаврыг АМГТГ-т өгч хэрэгжилтийг хангуулан ажилласны дүнд</p>	<p>100%</p>

						<p>олборлолтын хэмжээ өссөн байна. 2017 оны 6-р сарын 16-22-ны хооронд УУХҮЯ-ны Төрийн бичгийн даргын 85 дугаар тушаалаар УУХҮЯ, АМГТГ-ын удирдах болон холбогдох хүмүүсийн бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг байгуулан бүх аймгууд сумдаар ажиллуулж салбарын цаг үеийн асуудал, Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг суртчилан танилцуулж, зарим аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай газар дээр танилцаж, харилцан мэдээлэл тулгамдаад байгаа асуудлуудаар санал солилцсон. Монгол Банкнаас санаачилсан “Монгол алт” аяны хүрээнд алт тушаалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран үйл ажиллагаа явуулж, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төвд “Монгол Алт” төрийн байгууллагуудын хамтарсан өдөрлөгийг зохион байгуулж хөтөлбөрийн хэрэгжилт, алт нийлүүлэлтийн сүлжээг албажуулах, алтны хууль бус ажиллагааг бууруулах талаар хэлэлцүүлэг хийгдсэн. Санхүүжилт шаардлагатай байгаа алтны 130 төслийн судалгааг гаргаж Хөгжлийн банкинд хүргүүлсэн ба одоогийн байдлаар Хөгжлийн банк зээллэг хүссэн 25 аж ахуйн нэгжийг судалж, материалын бүрдэл хангасан 8 аж ахуйн нэгжид 24,8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон.</p> <ul style="list-style-type: none"> • “Алт агуулсан хүдэр, элс олборлож баяжуулах, хамгаалах, хадгалах, хамгаалах, хүлээлцэх, тээвэрлэх худалдахтай холбогдсон журам”-ыг төслийг боловсруулан, сонсох үйл ажиллагаа явуулж байна. • Алтны хэтийн төлөв бүхий бүс, нутгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр Монгол орны алтны хэтийн төлөвийг үнэлэх, алтны эрэл-үнэлгээний
--	--	--	--	--	--	---

						<p>сэдэвчилсэн судалгааны ажлыг 2017 онд Монгол орны төв, зүүн бүсийн хэмжээнд гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зарлаж, шалгарсан гүйцэтгэгчтэй зөвлөх үйлчилгээний гэрээ"-г байгуулан ажлыг эхлүүлээд байна. Хайгуулын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтаар олгох талбайн солбицолыг тогтоох тухай Засгийн газрын 2017 оны 37 дугаар тогтоолыг батлуулсан. Хайгуулын тусгай тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох талбайн солбицлыг тогтоох тухай Засгийн газрын 2017 оны 106 дугаар тогтоолыг батлуулсан. Засгийн газрын 2017 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Сонгон шалгаруулах журмаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицол”-д 1.61 сая га талбайг нэмж Засгийн газрын 2017 оны 234 дугаар тогтоолоор батлуулсан. Алтны шороон ордын 25, үндсэн ордын 4 хайгуулын ажлын үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн улсын нөөцийн санг 6226.81кг нөөцөөр нэмэгдүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/62, А-98 тоот хамтарсан тушаалаар Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх талаар судалгаа хийж, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монголбанк, Стандарт хэмжил зүйн газар, “Эрдэнэс Монгол”ХХК -ийн төлөөлөл оролцсон Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн календарчилсан төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн технологийн харьцуулсан судалгааны ажлыг гүйцэтгэсэн. 	
--	--	--	--	--	--	--	--

						<ul style="list-style-type: none"> • 2017 оны 12 сарын 31-ний байдлаар нийт 20,01 тн алт Монголбанкинд тушаагдаад байна. • Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/48 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо"-г шинэчлэн байгуулсан. • "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын түр журам"-ын төслийг боловсруулж, сонсох ажиллагаа явуулж байна. <p>5-р зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • "Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам" болон "Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ын боловсруулан 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. "Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журам" болон "Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/93 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулж, дээрх 2 журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. • "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг шинэчлэн боловсруулж, 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн газрын 151 дүгээр тогтоолоор батлуулсан. 		
5.4	МУТХҮБ-ын 2.1.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.61 дэх заалт	Ашиглахад бэлэн болсон уурхайн үйл ажиллагааг эхлүүлэх,	1. Ашигт малтмалын тухай хуулийн 35.4-т заасны дагуу ашиглахад	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0		1. 2017 онд нийт 46 аж ахуйн нэгж хүсэлт ирүүлсэн. Комисс ажлуллахаар хүсэлтээ ирүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй холбоо тогтоож бичиг баримтын бүрдэл хангасан 20 уурхай, 1 баяжуулах үйлдвэрт Улсын комисс ажиллаж, цаашдын үйл	100%

		олборлолт, экспортыг нэмэгдүүлэх	бэлэн болсон уурхайг улсын комиссоор хүлээн авах				ажиллагаандаа хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг өгч, хүлээн авсан. Бусад бичиг баримтын бүрдэл хангаагүй-18, бичиг баримтын бүрдэлээ ирүүлээгүй-7 аж ахуйн нэгж байна. Комисс 9 удаа ажилласан.	
5.5	МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 3, 4 ЗГҮАХ-ийн 2.71, 2.72, 2.73 дахь заалт	Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	1. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг хүлээж авч үнэлэлт, дүгнэлт өгөх	Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар	100.0		1.Засгийн газрын 2017 оны 88 дугаар тогтоолоор "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх байршил болон хүчин чадал өөрчлөгдсөнтэй холбогдуулан Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн захиалгаар хийж гүйцэтгэсэн БНХАУ-ын "ENFI" компанийн боловсруулсан ТЭЗҮ-г тодотгох боломжгүй болсон. Цаашид Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн хөрөнгө оруулагч үйлдвэрийн хүчин чадал, байршилд тохируулан ТЭЗҮ-г шинээр боловсруулах шаардлага тулгарч байна. Үйлвэрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/109 тоот тушаалаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр" барих талбайн байршлыг төмөр зам, эрчим хүчний хангамж болон бусад дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлттэй уялдуулан тодорхойлох зорилгоор "Оюутолгой" ХХК-ын удирдлага болон орон нутгийн төр, захиргааны байгууллагуудтай Өмнөговь аймагт уулзалт зохион байгуулж ажилласан бөгөөд ЗТХЯам, "Оюутолгой" ХХК болон "Монголын Төмөр Зам" ТӨХК-тай үйлдвэрийн байршлын асуудлаар хэлэлцэж газрыг урьдчилсан байдлаар товлон, 2018 оны газар хуваарилалтын төлөвлөгөөнд тусгуулахаар холбогдож материалыг бүрдүүлэн Өмнөговь аймгийн Засаг даргад 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 3/2235 тоот албан албан бичгээр хүргүүлсэн.	70%

			2. Шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийн тайланг хүлээн авч, үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг хангах	“Уул уурхай металлургийн цогцолбор” төслийн 2 дугаар шатны бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	10.0		2. “Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл”-ийн ТЭЗҮ-ийн эцсийн тайланг 2017 оны 9 дүгээр сард уг төслийн зөвлөх “Hatch” компани ажлын хэсэгт танилцуулсан ба ТЭЗҮ-ийг урьдчилсан байдлаар хүлээн авсан. Тус төслийн БОННУ-г 2018 оны I улиралд хүлээн авахаар Дэлхийн банкнаас хугацааг сунгасан.	70%
			3. Газар доогуур инженерийн шугам сүлжээ байгуулах ажлыг эхлүүлэх				3.. Газар доогуур инженерийн шугам сүлжээг байгуулах зураг төслийн ажлыг хийж гүйцэтгэж байна. Мөн Төвийн дулааны шугам сүлжээнд гангийн үйлдвэрийн барилгыг холбосон.	40%
			4. Үйлдвэрийн барилгын ажлыг дуусган, тоног төхөөрөмжийг суурилуулж, үйлдвэрийг ашиглалтад оруулах				4. “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК нь евро стандартад нийцсэн, жилд 20 000 тонн ган бөмбөлөг үйлдвэрлэх хүчин чадалтай, давтах аргын технологитой үйлдвэрийг ашиглалтанд оруулж, 2017.01.28-ны өдөр нээлтээ хийсэн. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийг Герман Улсын "Shuler" компани, бусад дагалдах төхөөрөмжийг Итали улсад үйлдвэрлэж, нийлүүлсэн.	100%
			5. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулж, төслийн бэлтгэл ажлыг хангах	Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах , байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх ажлын явц хувиар	100.0		5. Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн “Төслийн нэгж байгуулах” тухай 107 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолоор “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл”-ийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий төслийн нэгжийг байгуулахыг УУХҮЯ-ны сайдад даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/43 дугаар тушаалаар нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр, хий дамжуулах	100%

						шугам хоолойн бүтээн байгуулалттай холбоотой бэлтгэл ажлыг зохион байгуулах үүрэг бүхий төслийн нэгж байгуулагдсан.	
			6. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төслийн урьдчилсан болон нарийвчилсан ТЭЗҮ-ийг хүлээн авч үнэлэлт, дүгнэлт өгөх			6. “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл”-ийн үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийн эцсийн тайланг 2017 оны 5 дугаар сарын 5-нд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн Хүнд үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж хүлээн авсан.	100%
			7. Байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээг хүлээн авч, үнэлэлт, дүгнэлт өгөх		100.0	7. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төслийн “Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ”-г гүйцэтгэгч “Грийн трендс” компани урьдчилсан тайлангаа 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдөр УУХҮЯаманд хүлээлгэн өгсөн. Урьдчилсан тайланд төслийн нарийвчилсан ТЭЗҮ-тэй холбоотой зөвлөмж, дүгнэлтүүд гарсан бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нэгж”-ээс холбогдох саналыг Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компанид хүргүүлсэн. Зөвлөх компани дээрх зөвлөмж, дүгнэлтийг нарийвчилсан үнэлгээнд тусган 2017 оны 08-р сарын 24 өдөр эцсийн тайланг хүлээлгэн өгөөд байна. Зөвлөх компани “Бүс нутгийн байгаль орчны үнэлгээний тайлан”-г “Дэлхийн банк”, “Уул уурхайн дэд бүтцийг хөгжүүлэх” төслүүдэд хүргүүлж, дүгнэлт гаргуулсан.	100%
5.6	МУТХҮБ-ын 2.1.3,	Газрын тосны эрэл,	1. Төсөл хэрэгжүүлэх	Нарийвчилсан ТЭЗҮ, зураг	100.0	Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн “Төрийн өмчит компани”	70%

	Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.63, 2.70 дахь заалт	хайгуул, олборлол тыг тогтвортой нэмэгдүүлж, газрын тос боловсруу лах үйлдвэрийг барих бэлтгэл ажлыг хангах	нэгж байгуулж, төслийн бэлтгэл ажлыг хангах	төсөл боловсруулах явц, хувиар			байгуулах тухай 92 дугаар тогтоол батлагдаж “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийг хэрэгжүүлэх 100 хувь төрийн өмчит компани байгуулахаар шийдвэрлэсэн. Уг тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн “Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай” 108 дугаар тогтоол батлагдаж “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-г хийж гүйцэтгэх Зөвлөх компанийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2017 оны 02 дугаар сараас 08 дугаар сарын хооронд зохион байгуулж улмаар Энэтхэг Улсын “Инженерс Индия Лимитед” компани шалгарч Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гурвалсан гэрээг УУХҮЯ, Монгол газрын тос ТӨХХК-тай 8-р сарын 9-нд байгуулсан. Гэрээний дагуу зөвлөх компанийн төлөөлөгч нар нарийвчилсан ТЭЗҮ хийх ажлын хүрээнд Монгол Улсад 2017 оны 09 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд албан айлчлал хийж Дорноговь аймгийн Сайншанд, Алтанширээ сумдад ажиллаж, үйлдвэр барих талбай, үйлдвэрт ашиглах усны эх үүсвэрийн талбай, бусад дэд бүтэцтэй танилцсан. Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компани үйлдвэрийн байршил, дамжуулах хоолойн трассын төлөвлөлттэй холбоотой байрзүй, геодези, инженер-	
--	--	---	--	--------------------------------------	--	--	---	--

						<p>геологи, усны судалгааны ажлыг хоёр улсын Зээлийн ерөнхий хэлэлцээрт тусгасны дагуу Монгол Улсын туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхээр болж туслан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2017 оны 08-10 дугаар сарын хооронд зохион байгуулж "Престиж Инженеринг" ХХК шалгарч 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээг Зөвлөх компанитай байгуулж, орон нутагт хийх судалгааны ажлыг эхлүүлээд байна.</p>	
			<p>2. Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн эхний, дундын, эцсийн тайлангуудыг тус тус хүлээн авч үнэлэлт, дүгнэлт өгөх</p>			<p>УУХҮСайдын 2017 оны А/208 тушаалаар "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулахад шаардагдах мэдээ мэдээлэл, тоо баримт бэлтгэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, төслийн судалгааны ажилд шаардлагатай газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа, стандарт, дүрэм журам, үйлдвэрийн байршил, дамжуулах хоолойн трассын төлөвлөлттэй холбоотой байр зүй, геодези, инженер-геологи, байгаль орчин, цаг уур, дэд бүтэц, түүхий эдийн хангамж, зах зээлийн талаарх мэдээ, мэдээлэл, тоо баримт, судалгаа шинжилгээний материалуудыг Энэтхэгийн Зөвлөх компанид бэлтгэн хүргүүлсэн. Дээрх мэдээ, мэдээлэлд үндэслэн БНЭУ-ын Зөвлөх компани төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн Эхлэлийн тайланг (Inception Report) 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ирүүлээд байна. Төслийн ТЭЗҮ-ийн тооцоо, судалгаа, техник, тоног төхөөрөмжийн сонголт, үйлдвэрийн болон дамжуулах хоолойн технологийн горимийг Монгол Улсын нөхцөл байдалд тохируулсан эсэхэд хяналт тавих үүднээс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын</p>	70%

							газрын санхүүжилтээр нарийвчилсан ТЭЗҮ-д хөндлөнгийн хяналт тавьж, дүгнэлт гаргах “Захиалагчийн инженер” (Owner’s Engineer) компанийг нээлттэй сонгон шалгаруулах ажлыг 2017 оны 08-11 дүгээр сарын хооронд зохион байгуулж, Итали Улсын “КТ-Кинетикс технолоджи СПА” компани шалгарч гэрээ байгуулах хэлэлцээрийн шатандаа явж байна.	
Хэрэгжилтийн дундаж							88,4	

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР